Батлав

Сумын засаг дарга Б.Баасантогтох

2025 оны 04 дүгээр сарын 15 өдөр

Төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг дарж булшлах , шинээр хог хаягдал цуглуулах байгууламжын ажлын даалгавар

2025 оны 04 дүгээр сарын 15 ны өдөр Цахир сум

1	Ажлын даалгавар боловсруулах үндэслэл:	Сумын засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр , Хоггүй Цахир хөтөлбөрийг хэрэгжүүлэх
2	Зориулалт, шаардлага:	Цахир сумын төвлөрсөн хогийн цэгийн га талбай ихэсч мал аж ахуй , хүн амын эрүүл мэнд , байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа тул дарж булшлах га талбайн хэмжээг бууруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.
3	Байршил , эдэлбэр газрын хэмжээ:	Цахир сумын Жинст багийн нутагт байрлах Төвлөрсөн хогийн цэгийн эзлэх нийт талбайн хэмжээ 3,2 га үүнээс цэвэрлэж дарж булшлах , талбайн хэмжээ 2.8га байна. Нийт талбайн хэмжээ болон цэвэрлэх талбайн зургийг хавсаралтаар тусгав.
4	Гүйцэтгэх ажлын зохион байгуулалт:	1. Шинээр үүссэн ахуйн хог хаягдал машины кузов , энгийн хатуу хог хаягдлыг Төвлөрсөн хогийн цэгт байрлах ашиглахгүй үлдсэн хуучин карьерт зөөвөрлөж булшилсан хогийн дээгүүр хар шороон хөрсөөр 60-смээс багагүй зузаантай хучилт хийнэ. 2.. сумын төвийн хогийн цэгийг 56:56 хэмжээтэй 4 метр гүнтэй хог хаягдал цуглуулах байгууламж ухаж бэлтгэх. Хар шороон хөрсийг байгууламжийн нийт талбайг тойруулан , ухаж эхэлсэн эрмэгээс 2 метр зайд , 1метр өндөр , 2метрээс багагүй өргөнтэй тэгш жигд байршуулна. 3. Харуулын байрнаас 20-30 метр зайд 2 дахь түүхий эд хүлээн авах 0,7 га газрыг шигүү 3м өндөр, хог тээвэрлэхэд саадгүй гүйдэг хаалгатай , бат бэх цоожтой торон хайсаар тойруулан хашна..

Scanned with CamScanner

5	Ажлыг зохион байгуулах үе шат , хугацаа:	Захиалагч , гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
6	Тавигдах шаардлага:	- Гүйцэтгэгч байгууллага Хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангаж тэмдэг тэмдэглэгээ , санамж , анхааруулага байршуулан шөнийн цагаар гэрэлтүүлэх хэрэгсэл болон гэрэл ойлгогч цацруулагчтай тууз туг дарцгийг байршуулж ажиллах. - Хог тээврийн болон бусад төрлийн тээврийн хэрэгсэлд саад учруулахгүй байх Дараах байгууллагуудтай заавал зөвшилцсөн байна. - Цахир сумын Засаг дарга - Засаг даргын Тамгын Газрын ажлын алба - Байгаль орчны тасаг - Бусад
7	Захиалагч байгууллага:	Цахир сумын Засаг Даргын Тамгын Газар
8	Хөрөнгийн эх үүсвэр , төсөвт өртөг	Орон нутгийн төсөв , 70.000.000 төг

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ **Д.БУЛГАНТОГТОХ**

Scanned with CamScanner



Scanned with CamScanner